

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2022 – 03 сар | Дугаар 40

## ГАРЧИГ

- 1–4 Бодлогын нийтлэл
- 5–8 Зохицуулалтын мэдээ
- 9–10 Байр суурь
- 11 Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүний төрлүүд
- 12 финтек дэх хэрэглэгчийн эрсдэл
- 13–17 Судлаачийн индэр
- 18–20 Санхүүгийн боловсрол
- 21–22 Компанийн засаглал
- 23–24 Олон улсын зах зээлийн мэдээ
- 25 Олон улсын хөрөнгийн зах индекс

## НОГООН ДААТГАЛ

Дэлхий нийтийн хэмжээнд тулгараад буй Дхамгийн том асуудал нь цаг уурын өөрчлөлт, хүрээлэн буй орчны доройтол гэдэгт олонх улс орнууд санал нэгдээд байна. Тиймдээ ч НҮБ-аас баталсан “Тогтвортой хөгжлийн зорилтууд–2030”-д байгаль орчин, экосистемийн доройтолтой тэмцэх, цаг уурын өөрчлөлтийг даван туулах цогц зорилгын хүрээнд 17 зорилтыг хэрэгжүүлэхээр дэлхийн бүх улс орнууд хүчин чармайлт гарган урагшилж байгаа ба зорилтуудад хүрэх голлох арга замуудын нэг нь тогтвортой санхүүжилт юм. Харин ногоон санхүүжилт нь тогтвортой санхүүжилтийн үндсэн нэг хэсэг гэж ойлгож болно.

Даатгалын салбарын хувьд ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалт гэсэн үндсэн хоёр хэлбэртэйгээр оролцож байна. Ногоон даатгалын /eco-friendly/ буюу хүрээлэн буй орчинд ээлтэй даатгалын бүтээгдэхүүний хувьд цаг уурын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол зэргийг бууруулахад дэмжлэг болохоос гадна, даатгуулагч, олон нийтэд энэ чиглэлийн мэдлэг ойлголт, дадал хэвшлийг суулгах нэгээхэн том хөшүүрэг болдгоороо онцлогтой.

Олон улсын хэмжээнд авч үзвэл томоохон даатгалын компаниудаас эхлээд ногоон даатгалын бүтээгдэхүүнийг хурдацтайгаар



нэвтрүүлэн ажиллаж байна. Түгээмэл нэвтэрсэн бүтээгдэхүүнүүдээс дурдвал:

1. **Тээврийн хэрэгсэл.** Цахилгаан, бензин болон цахилгаан хосолсон /хайбрид/, авто хийн, ус төрөгчийн зэрэг байгаль орчинд үзүүлэх бохирдол багатай хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгслийг тодорхой хөнгөлөлт, урамшуулалтайгаар даатгах үйлчилгээ өргөн нэвтэрч байна. Мөн эсрэгээрээ утаа их ялгаралтай буюу байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө ихтэй /дизель хөдөлгүүртэй, насжилт урттай/ тээврийн хэрэгслийг даатгалд хамруулахдаа тодорхой шалгуурын дагуу эрсдэлийн түвшнийг бусад төрлөөс өндрөөр тооцож хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх хандлагатай байна.

Түүнчлэн тээврийн хэрэгслийг засварлах боломжгүй болох даатгалын тохиолдолд нөхөн төлбөрт байгаль орчинд хор хөнөөл багатай /цахилгаан, ус төрөгчийн, хийн хөдөлгүүртэй/ тээврийн хэрэгслийг санал болгох зэргээр шинэлэг чиг хандлага нэвтэрч байна.

PAYD /Pay-As-You-Drive/ гэгдэх даатгалын гэрээний төрлийг мөн энд дурдаж болно. Тус гэрээгээр даатгуулагч нь тээврийн хэрэгслээ ашиглан замын хөдөлгөөнд оролцож, бохирдол үүсгэхийн оронд алхах, дугуй унах зэрэг эрүүл мэндэд эерэг нөлөөтэй, хүрээлэн буй орчинд бохирдол үүсгэхгүй зорчих арга замуудыг сонгон автомашин ашиглах хэмжээгээ багасган даатгалын хураамжийн хэмжээгээ хөнгөлүүлэх боломжтой.

2. **Барилга, байгууламж.** Барилгын салбарт мөн ялгаагүй хүрээлэн буй орчинд хор хөнөөл багатай материал ашиглах замаар ногоон хөгжлийг дэмжих туршлагауд нэвтрээд байна. Улс орнууд байгальд ээлтэй гэсэн ангилал, шалгуурыг бий болгон барилга, амины орон сууцыг тухайн шалгуураар үнэлдэг. Байгаль орчинд ээлтэй үнэлгээтэй байна тэр хэмжээгээр даатгалын болон бусад чиглэлээр хөнгөлөлт, урамшуулалд хамрагддаг.

Үргэлжлэл 2-р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### НАЙДВАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

Алдагдал болон бүртгэгдсэн байсан зээлийн эргэн төлөлт. Уг зээл нь аль хэдийн зээлийн эрсдэлийн сангаас хасагдаж тооцогдсон байдаг учраас, энэхүү эргэн төлөлт нь зээлийн эрсдэлийн сан эсвэл хуваарилагдаагүй ашгийг нэмэгдүүлдэг.



### RECOVERY OF BAD LOAN

A revenues and costs in relation to sales and determines the level of sales at which the activity will begin to make a profit.

Эх сурвалж:  
Банк санхүүгийн тайлбар толь бичиг

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### НОГООН ДААТГАЛ

Өмнөх нь 1-р нүүрт

Түүнчлэн барилга, орон сууцанд даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд эргэн засварлахдаа даатгалын компаниудаас байгальд ээлтэй бараа материалыг санал болгох гэрээний нөхцөлүүдийг энд дурдах нь зүйтэй.

Мөн иргэд, даатгуулагчид дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр санаачилга гарган даатгал, зээлийн үйлчилгээнд хамрагдах боломжууд бий болж байна. Хөгжингүй улс орнуудад иргэд амины орон сууцандаа сэргээгдэх эрчим хүчний / нар, салхи, ус/ эх үүсвэрийг ашиглаж байгальд сөрөг нөлөөтэй эрчим хүчний эх үүсвэрээс авах хэрэглээгээ багасгах, татгалзах чиг хандлагууд ихээхэн ажиглагдаж байгаа бөгөөд энэ тал дээр мөн даатгалын компаниуд бүх төрлийн эрсдэлийг нь хариуцаж, дэмжин ажиллаж байна.

3. Ногоон бизнес. Сэргээгдэх эрчим хүчний салбар энэ чиглэлээр олон улсад томоохон байр суурь эзлэх хандлагатай байна. 2016 оны Парисын хэлэлцээрээр улс орнуудын тэргүүнүүд хүлэмжийн хийн ялгарлыг багасгах амлалт өгсний дагуу сэргээгдэх эрчим хүч, байгаль орчныг нөхөн сэргээх, хүрээлэн буй орчинд хор хөнөөл багатай бизнес үйл ажиллагааг бодлогоор дэмжиж байгаа нь даатгалын салбарт мөн нөлөөлсөн. Даатгалын компаниуд сэргээгдэх эрчим хүчний бизнесүүдийг даатгах сонирхол илт нэмэгдсэн. Мөн эрчим хүчний салбараас гадна ногоон гэгдэх

бусад бизнесүүдийг ч ялгаагүй түлхүү дэмжих хандлагатай байна.

Ногоон даатгалын бүтээгдэхүүний үр нөлөө, давуу талууд


Даатгалын компаниуд ногоон даатгалыг зах зээлдээ нэвтрүүлснээр шууд бусаар байгаль орчинд ээлтэй зан төлөвийг даатгуулагчдад бий болгох, шинэ төрлийн ногоон төсөл, технологиудын эрсдэлийн хамгаалалтыг бүрдүүлэн цаашдын хөгжилд нь түлхэц үзүүлэх нөлөөтэй бол шууд байдлаар дараах үр нөлөөг үзүүлдэг.

#### Зах зээлийн өсөлт

Жишээлбэл, хайбрид болон бүрэн цахилгаан тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн хөнгөлөлт нь цаашдын автомашины зах зээлийн хандлагыг тодорхойлж буй цахилгаан тээврийн хэрэгслийн салбар, хэрэглэгчдийг өөртөө татан зах зээлээ тэлэх том боломжийг бий болгож байна.

#### Бизнесийн тэлэлт

Олон улсын хэмжээнд засгийн газрууд сэргээгдэх эрчим хүчний салбарт ихээхэн анхаарал хандуулж байгаа ба ойрын ирээдүйд хамгийн ихээр өргөжих салбаруудын нэг болоод байна. Эдгээр төслүүдийн салшгүй нэг хэсэг нь даатгалын салбар байх тул ногоон даатгалын чиглэлд анхаарал хандуулснаар



даатгалын зах зээл тэлэх ихээхэн боломж бүрдэж байгаа юм.

### Эерэг нэр хүнд

Ногоон даатгалын бүтээгдэхүүнийг өргөн хүрээнд нэвтрүүлсэн компаниуд нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой ногоон хөгжлийг дэмжиж ажилладаг гэсэн эерэг нэр хүндтэй болдог ба энэ нь эргээд олон нийт, төр засагтай харилцах харилцаанд сайн үр дүнг авчирдаг байна. Энэ нь компанийн маркетингийн үйл ажиллагаанд эерэг түлхцийг өгдөг.

### Хөрөнгө оруулалт

Олон улсын томоохон даатгалын компаниуд ногоон хөтөлбөрүүдэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа ба цаашдаа ч хурдацтай өсөх хандлагатай байна. Жишээлбэл, зөвхөн Япон Улсын Dai-ichi life insurance компани нь Европт 307 сая.доллар, Хойд Америкт 153 сая.доллар, Азид 63 сая.доллар, Өмнөд Америкт 83 сая.долларыг зөвхөн сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд хөрөнгө оруулаад байна. Мөн бондын хувьд авч үзвэл

Швейцарын Zurich Insurance зөвхөн 2019 оны байдлаар гэхэд 3.1 тэрбум.долларыг ногоон бондод хөрөнгө оруулсан.

### Зарчим

Ногоон даатгалын хувьд зарим хөгжингүй орнуудад ч гэсэн шинэ ойлголт байсаар байна. Ногоон даатгалын голлох зарчмууд нь дараах үндсэн агуулгатай байна. Үүнд:

#### Ногоон бодлого

Бодлого боловсруулагчид салбарын хүрээнд ногоон санхүүжилтийг дэмжих, ногоон бизнес үйл ажиллагаанд анхаарах замаар олон нийтийн хандлага, дадалд нөлөөлөх;

#### Хураамжийн менежмент

Хураамжийн орлогын тодорхой хэсгийг, эсвэл ногоон даатгалын бүтээгдэхүүнээр дамжин орж ирсэн хураамжийн орлогыг ногоон хөрөнгийн ангилал бий болгон тус ангиллаас ногоон төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох, хөрөнгө оруулах;

#### Даатгагчийг/Төслийг сонгох



Даатгагч, брокерууд нь нийгэмд байгаль орчноо хамгаалах эерэг нөлөөллийг үзүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллах, ногоон эдийн засгийг бий болгоход чиглэх;

### **Бизнесийн үйл ажиллагаа**

Өөрсдийн бизнесийн үйл ажиллагаандаа эрчим хүчний хэмнэлттэй, карбоны ялгарал бага, байгаль орчны хортой нөлөөлөлгүй зарчмыг баримтлах;

### **Андеррайтингийн модуль**

Даатгагч нар нь “Цаг уурын өөрчлөлт”, “Карбоны ялгарал” зэрэг хүчин зүйлүүдийг өөрсдийн эрсдэлийн модульдаа авч үзэх шаардлагатай. Энэ нь эргээд байгаль орчинд сөрөг нөлөөлөлтэй салбар, үйл ажиллагааны эрсдэлийн багцыг илүү өргөн хүрээнд харах боломжийг бүрдүүлнэ;

### **Бүтээгдэхүүний хөгжил**

Карбон ялгарлыг багасгах, байгаль орчинд ээлтэй технологийг дэмжих үүднээс даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, нэвтрүүлэх;

### **Тайлагнал**

Олон улсын зарчим, уриалгуудын дагуу ногоон даатгалын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудаа нийтэд тогтмол тайлагнах.

Монгол Улсын хувьд Ногоон даатгал нь харьцангуй шинэ ойлголт юм. Санхүүгийн салбарын хувьд 2019 он 12 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Ногоон таксономи”-ийг баталсан. Таксономийн хүрээнд банк, бичил санхүүгийн байгууллагууд ногоон ангилалд хамаарах зээлийг зээлдэгчдэд хүргэж байна.

Харин даатгалын салбарын хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос ногоон даатгалын эрх зүйн суурь зохицуулалтыг бий болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан Даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”, хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”, дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”, арван нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл

гаргах заавар”-т тус тус холбогдох өөрчлөлтийг оруулах тогтоолын төслийг боловсруулсан. Мөн Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу иргэд, олон нийтээс санал авахаар 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулж, ирүүлсэн саналын дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр Санхүүгийн зохицуулах хорооноос ногоон даатгалын чиглэлээр баримталж буй бодлого, өнөөгийн нөхцөл байдал, журмын нэмэлт, өөрчлөлтийн төсөл, олон нийтээс ирүүлсэн саналыг тусгасан эсэх мэдээллийг танилцуулснаас гадна даатгалын компаниуд нь ногоон хөгжил, ногоон даатгалын чиглэлээр өөрсдийн хэрэгжүүлж буй ажлууд болон цаашид хэрэгжүүлэхээр судалж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар танилцуулж, энэ чиглэлээр нэгдсэн бодлого баримтлан, цогц үйл ажиллагаа явуулах шаардлагатай байгаа талаар санал дэвшүүлж оролцсон. Улмаар ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэх чиглэлээр бусад санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, салбарын хэмжээнд баримтлах бодлого, чиглэлийг боловсронгуй болгоход дэмжин ажиллахаа илэрхийлсэн.

Үүний дагуу Даатгалын багц дүрмийн холбогдох журам, заавруудад “ногоон даатгал”-ын үйл ажиллагааг тодорхойлон, даатгалын компаниудыг ногоон бондод хөрөнгө оруулахыг бодлогоор дэмжсэн, ногоон даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоод зах зээлийн дата, мэдээлэл бий болгох зохицуулалтыг нэмж Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор баталсан. Ингэснээр олон улсын хэмжээнд хэрэгжиж буй тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх гол арга хэрэгсэл болох ногоон санхүүжилтийн экосистемийг бүрдүүлэхэд даатгалын салбарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломж бий болж байна.

Мөн ногоон даатгалын бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрснээр цаг уурын өөрчлөлт, хүрээлэн буй орчны бохирдол зэргийг бууруулахад дэмжлэг болж, иргэд, даатгуулагчдын байгаль орчинд ээлтэй, бүтээгдэхүүн үйлчилгээ авах, хүрээлэн буй орчны бохирдолтой тэмцэх дадал, хэвшлийг суулгахад хөшүүрэг болохоос гадна хөрөнгийн зах зээл дэх ногоон санхүүжилтийг дэмжих, улмаар ногоон хөгжлийн төсөл хөтөлбөрүүд нэмэгдэх ач холбогдолтой юм.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### СЭТГҮҮЛЧИДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Салбарынхан болон олон нийтэд үнэн бодит мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэх нь санхүүгийн салбарын ил тод байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой байдаг. Иймд Санхүүгийн зохицуулах хороо Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клубын сэтгүүлчидтэй уулзалт хийлээ. Уулзалтад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, дэд дарга Н.Хүдэрчулуун, Ажлын албаны дарга Т.Жамбаажамц болон холбогдох газрын дарга нар оролцож зохицуулалттай салбаруудын онцлог, санхүүгийн зах зээлийн төлөв байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулж, мэдээлэл өгөхийн зэрэгцээ чөлөөт ярилцлага өрнүүллээ.

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд 6397 санхүүгийн болон зах зээлийн мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавин ажиллаж байна.

УИХ, Засгийн газраас хөрөнгийн зах зээлийг дэмжиж ажилласны үр дүнд Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын орчныг бүрдүүлж, зах зээлийн мэргэжлийн оролцогчид, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчидтай хамтран бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг

нэмэгдүүлэх, хөгжүүлэх, дотоодын болон гадаадын хөрөнгийн бирж хооронд үнэт цаас хөрвүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тогтолцоог бүрдүүлэх зэргээр бодлогын томоохон арга хэмжээг хэрэгжүүлж чадсан. Үүний үр дүнд санхүүгийн салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 24 хувьд хүрч өссөн, тэр дундаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 97.5 хувиар өсч хөрөнгийн зах зээлийн түүхэндээ хамгийн дээд түвшинд хүрсэн. Заримаас нь дурдвал, монголын үндэсний төгрөг болон ам.долларын хосолсон бонд гарсан. Нээлттэй хувьцаат компани болох банкны бүтцийн өөрчлөлтөд оролцохоор хамтын хөрөнгө оруулалтын сан нэгж эрхээ амжилттай арилжаалсан. Мөн биржийн бус зах зээлээс татах зохицуулалтыг бүрдүүлж анхны цанг цохисон. Банкны системд нөлөө бүхий банкууд олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажил хэрхэн хангагдаж байгаа талаар мэдээлэл өгсөн юм.

Харин энэ онд санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг шинэчлэх, технологийн шинэчлэлийг дэмжих хүрээнд холбогдох хуулиудын төслийг боловсруулж УИХ-аар батлуулах, хяналтын орчныг уян хатан, боловсронгуй болгож, виртуал хөрөнгийн үйлчилгээний зохицуулалтыг хэрэгжүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мөнгө угаалттай тэмцэх, 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх чиглэлд хийж хэрэгжүүлэх ажлуудаа танилцууллаа.

### ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХОЛБОГДОХ ЖУРМЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЛЭЭ

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль болон нэр бүхий 13 өргөн мэдүүлсэн хуулиуд нь “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хэвлэгдсэнээр мөн сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-ноос нийт 10 орчим харилцааг зохицуулахаар нэр бүхий 8 журмыг боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. Одоогоор эхний 4 журмын төслүүдийг олон улсын тэргүүн туршлага, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/, олон улсын стандарт, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, олон нийтээс санал авахаар өнгөрсөн сарын 25-нд СЗХ-ны цахим сайтад байршуулсан.

Үүнтэй холбогдуулж виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдээс “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”, “Виртуал хөрөнгийн



үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журам” –ын төслүүдэд санал авах хэлэлцүүлгийг танхим болон цахим хэлбэрээр энэ сарын 22-нд зохион явууллаа.

Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэгт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын төлөөлөл, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Улсын прокурорын ерөнхий газар, Терроризмтой тэмцэх зөвлөл болон Азийн сангийн төлөөлөл зэрэг 80 гаруй этгээд оролцов.



Хэлэлцүүлгээр СЗХ болон эрх бүхий байгууллагууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, эрх зүйн орчин, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг мэдээллийг өгч, дээрх журмын төслүүдийг танилцуулсан юм. Мөн “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн төлөөлөл журмын төслүүдэд саналаа нэгтгэж танилцуулсан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, үйлчлүүлэгч хөрөнгө оруулагчдын цахим аюулгүй байдал, үйл ажиллагаа, тайлан, мэдээ зэрэг асуудлуудыг хөндөж, саналуудыг тусгахаар хэлэлцлээ.

### **“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙГ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА**

Санхүүгийн зохицуулах хорооны энэ сарын 23-нд болсон ээлжит хуралдаанаар “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталлаа.

Компанийн засаглалын тогтолцоо үр дүнтэй байх нь компанийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурь нөхцөл тул энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос

2007 онд “Монгол Улсын компанийн засаглалын кодекс”-ийг батлан мөрдүүлж эхэлсэн бөгөөд улмаар 2014 онд өөрчлөлт оруулж байсан. Харин энэ удаагийн шинэчлэгдсэн кодекс бусад орны сайн жишиг болон манай орны нөхцөл байдалд үндэслэн компанийн засаглалын гол субъект болох төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүтэц, үйл ажиллагааны зарчмыг илүү тодорхой, нарийвчлан зааж, сайжрууллаа. Тодруулбал, ТУЗ нь өөрөө кодексийн хэрэгжилтийг хариуцах, хяналт тавихаар үүрэгжүүлсэн бол нээлттэй хувьцаат компаниас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад кодексийг үйл ажиллагаандаа мөрдөхийг үүрэг болгосноор хамрах хүрээ өргөслөө.

Түүнчлэн ТУЗ-ийн хараат бус гишүүний чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулах, зөрчлийг мэдээлэх болон комплайнсын хяналтын тогтолцоо болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахдаа зайны технологийг нэвтрүүлэхийг үүрэгжүүлээ. Үүний зэрэгцээ ТУЗ-ийн дарга, гишүүдийн олонхи нь хараат бус байх, ТУЗ-ийн зүгээс гадаад болон жижиг хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгой анхаарах зөвлөмжүүд ч туссан. Мөн компаниудад кодексийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд тус дөхөм болох зорилгоор уг кодексийн хавсралтаар “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар”-ыг боловсруулаад байна.

Компанийн ТУЗ нь кодексийн хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тайлагнахаас гадна жилийн үйл ажиллагааны тайландаа тусган, цахим хуудсандаа байршуулна. Хэрэв кодексийн хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэгдвэл тухайн үнэт цаасны бүртгэлийн ангилал буурах нөхцөл бүрдэх ба хөрөнгө оруулагчид санхүүгийн тоон үзүүлэлтийн харьцаанаас гадна компанийн засаглал талаас нь үнэлж, шийдвэрээ гаргах чанарын үзүүлэлттэй болох юм.

### **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ**

Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангаж хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, гадаад хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхээс гадна Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага / ФАТФ/-ын Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах үүднээс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг боловсруулж УИХ-аас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан. Хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10.9.1-д заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь виртуал хөрөнгийн



үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэл хийх, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зохистой засаглал, үйл ажиллагаа, тайлан мэдээнд тавих шаардлагыг тодорхойлох, аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох болон мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журмуудын төслийг тус тус боловсруулж, олон нийтээс санал авахаар байршуулсан.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлэх ажлын хэсэг, хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөлөл буюу Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Тагнуулын ерөнхий газар, Терроризмтой тэмцэх зөвлөл зэрэг байгууллагуудад дээрх журмын төслүүдийг танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр ФАТФ, Ази, Номхон Далайн Мөнгө Угаахтай Тэмцэх Байгууллага /АНДМУТБ/ эрх бүхий байгууллагуудын шаардлага, хууль тогтоомжийн уялдаа холбоо, үнийн манипуляц, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудлуудыг хөндөж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр санал солилцож ажиллав.

## САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн ээлжит бус хуралдаан энэ сарын 15-нд боллоо. Хуралдааныг Сангийн сайд Б.Жавхлан даргалж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч С.Баатарсүрэн болон бусад албаныхан оролцлоо.

Хуралдаанаар олон улсын төлбөр тооцооны нөхцөл байдал, шатахууны импорт дээр үүсээд буй тодорхой бус байдал болон валютын нөөцийг нэмэгдүүлэх арга замуудын талаар хэлэлцлээ. Мөн макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон юм. Хэлэлцсэн асуудлын хүрээнд Засгийн газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэхээр зөвлөмж гаргалаа.

## САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн хоёрдугаар сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлаар Монгол Улсын эдийн засгийн төлөв, гадаад орчинд үүсэж буй эрсдэл, тодорхой бус байдлын талаар хэлэлцээд макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх хүрээнд доорх чиглэлээр бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмж гаргалаа. Үүнд:

**Нэг.** Эдийн засгийн гадаад орчинд үүссэн нөхцөл байдалтай уялдуулан олон улсын төлбөр тооцооны тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах.

**Хоёр.** “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, худалдааны эргэлтийг сайжруулахад чиглэсэн боомтуудын өргөтгөл шинэчлэлт, бүтээн байгуулалтын ажлыг яаралтай дуусгах, БНХАУ-ын талтай харилцан тохиролцож, хилийн боомтуудын төлөвлөлт зохион байгуулалтыг нягт уялдуулан үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх.

**Гурав.** Хил орчмын бүс нутагт халдвар хамгааллын дэглэмийг чангатгах, хил нэвтрүүлэх зохион байгуулалтыг сайжруулах, экспортын тээвэрт хүний шууд оролцоог бууруулсан чингэлэгт тээврийн терминал, ухаалаг тээврийн хэрэгслийг (AGV) нэвтрүүлэх ажлуудыг шуурхайлах замаар экспортыг нэмэгдүүлэх.

**Дөрөв.** Замын-Үүд, Булган, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтууд, импортын бараа тээвэрлэлтийн шинэ замуудыг судалж, ашиглах замаар импортын бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн өртөг зардлыг бууруулах.

**Тав.** Гадаад, дотоод хүчин зүйлээс шалтгаалан нэмэгдсэн инфляцыг Улсын Их Хурлаас баталсан мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд Төв банкны дунд хугацааны зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

**Зургаа.** Эдийн засгийн сэргэлтийг дэмжих, үйлдвэрлэлийн суурь зардал, хэрэглээний үнийн дарамтыг бууруулж, иргэдийн бодит орлогыг хамгаалах хүрээнд эрчим хүч, цахилгаан дулаан, сайжруулсан түлш, цэвэр бохир ус, сургалтын төлбөр зэрэг төрийн зохицуулалттай үнэ болон бензин шатахууны үнийн тогтвортой байдлыг ханган ажиллах.

**Долоо.** Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гадаад төлбөрийн чадварыг дэмжиж, валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлого, үйл ажиллагаа, санхүүгийн зохицуулалтыг уялдуулан хэрэгжүүлэх.

## “ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ-2022” АЯН ЭХЭЛЛЭЭ

“Дэлхийн мөнгөний долоо хоног” аян эхэллээ. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ (OECD/INFE)–ээс зохион байгуулдаг хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулах



зорилготой тус аянг дэлхий нийтээр 10 дахь жилдээ тэмдэглэж байна.

Энэ сарын 27-ныг хүртэл үргэлжлэх “Дэлхийн мөнгөний долоо хоног-2022” аяны хүрээнд хүүхэд, залуучуудад санхүүгийн мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор орон даяар зохион байгуулна. Ингэхдээ “Хувь хүний санхүүгийн төлөвлөлт”, “Ирээдүй рүү чиглэсэн хуримтлал ба хөрөнгө оруулалт”, “Мөнгөө зөв удирдаж, ирээдүйн санхүүгийн сайн, сайхан, санхүүгийн эрх чөлөөнд хүрэх том алхам” зэрэг сэдвийн хүрээнд сургалт, уралдаан тэмцээн, нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион явуулах юм.

Аяныг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ, Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан, Зээлийн батлан даатлын сан, арилжааны банкууд, Рио Тинто ХХК, Юнител групп, Lemon Press компани, Мобифинанс ББСБ хамтран хэрэгжүүлж байна.

## БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫНХАН “ТЭРБУМ МОД” ХӨДӨЛГӨӨНД НЭГДЛЭЭ




Ерөнхийлөгчийн тамгын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд санхүүгийн салбарынхны оролцоог нэмэгдүүлэх, санал санаачилгыг өрнүүлэх зорилгоор салбарынхантайгаа ээлжит уулзалтуудыг зохион байгуулж байна. Энэ сарын 09-нд банк бус санхүүгийн салбарынхантай уулзалт зохион байгуулж, Ерөнхийлөгчийн эдийн засаг болон байгаль орчны зөвлөх, Санхүүгийн зохицуулах хорооны газрын дарга нар, Байгаль орчны яамны ойн бодлогын газрын удирдлага болон банк бус санхүүгийн салбарынхан оролцсон юм.

Салбарын төлөөлөл энэ үеэр мод тарих хөдөлгөөнийг идэвхтэй дэмжиж оролцохоо илэрхийлээд ногоон зээлийн бүтээгдэхүүн хөгжүүлж, ойн үржүүлгийн газар, иргэдийг хооронд нь холбох виртуал мод аппликейшнийг нэвтрүүлж байгаа таатай мэдээг дуулгалаа. Мөн ногоон санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, мод үржүүлгийн компаниудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх, энэ хөдөлгөөнд оюутан, сурагчдыг татан оролцуулах, сертификат олгох зэрэг санал санаачилгуудыг ажил хэрэг болгохоо илэрхийлсэн юм.

## БАЙР СУУРЬ

### ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ АРГА ХЭМЖЭЭ

*Санхүүгийн зохицуулах хорооны Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Н.Энхтүяатай ярилцлаа.*



**Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх үйл ажиллагаа нь хэзээнээс төрийн зохицуулалттай болсон бэ гэдэг асуултаар ярилцлагаа эхлүүлье.**

Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтад оруулсан бөгөөд энэ хүрээнд холбогдох үүрэг даалгаврыг Монгол Улсад өгсөн. Үүний нэг нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, хяналт зохицуулалттай болгох даалгавар байсан. Энэхүү чиглэлийн бодлого стратеги, зохицуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ

болох үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо ҮХХЗҮЭЗГ-ыг байгуулж, улмаар эрх зүйн орчныг бүрдүүлэн, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг бүртгэлжүүлж, тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн.

**Энэ төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгох нь ямар үр нөлөөтэй вэ?**

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй болгосон нь Монгол Улсад үнэт металл, үнэт чулууны салбарт олборлох, боловсруулах, арилжаа эрхлэх, цэвэршүүлэх, эдлэл үйлдвэрлэх, худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг анх удаа нэгдсэн бодлого, зохицуулалтад хамруулсан үйл явдал болсон. Монголбанк 2021 онд нийт 21 тонн үнэт металл худалдан авснаас 9.9 тонн буюу 47.1 хувийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 95 иргэдээс худалдан авсан бөгөөд урьдчилсан гүйцэтгэлээр тэдгээр иргэд нь нийт 753.1 тэрбум төгрөгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлсэн байна. Үүнээс үзэхэд энэ төрлийн үйл ажиллагааг хянаж, зохицуулах хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлснээр гадаад валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн ханшийг дэмжих, далд эдийн засгийг ил болгох зэрэг үр нөлөөтэй.

**Тэгэхээр энэхүү салбар маань зохицуулалттай болоод 2 жилийн хугацаа өнгөрсөн юм байна. Энэ хугацаанд хэчнээн**

**арилжаа эрхлэгчид тусгай зөвшөөрөл олгосон бэ?**

Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх нөхцөл шаардлагыг тогтоож, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх дүрэм журмуудыг баталсан. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 42 хуулийн этгээд, 438 иргэнд дээрх төрлийн тусгай зөвшөөрлийг олгож, бүртгэлжүүлэн хяналт тавин ажиллаж байна. Үүнээс, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 67 иргэн, 15 хуулийн этгээд, үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 242 иргэн, 22 хуулийн этгээд, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа 129 иргэн, 5 хуулийн этгээд бүртгэлтэй байна.

**Хяналт шалгалтын талаар мэдээлэл өгвөл?**

Санхүүгийн зохицуулах хороо хуульд заасан үндэслэл, журмын дагуу газар дээрх хяналт шалгалтыг хийх бөгөөд хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэж ангилдаг. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан шалгалтын удирдамжийн дагуу хийдэг. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын дагуу хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд газар дээрх үзлэг, шалгалтын төлөвлөгөөний дагуу нэр бүхий 2 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдэд газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэсэн бол ҮМҮЧЭТХЭАЭ нэр бүхий 16 хуулийн этгээд, 101 иргэн буюу нийт 117 этгээдэд газар дээрх үзлэгийг хийж гүйцэтгэн үзлэг шалгалтын тайланг гаргаж, тайлангийн нэгтгэлийг Санхүүгийн зохицуулах хорооны удирдлагуудад танилцуулсан.

**Цаашид энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулсан салбарын бие даасан хууль, эрх зүйн зохицуулалттай болох уу?**

Тэгэлгүй яахав. Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-62/63/31/А26 дугаар хамтарсан тушаалаар “Монгол улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ыг баталсан. Тус бодлогын баримт бичгийн 2021-2025 онд хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөний 4.17-д үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан хууль, дүрэм, журмын төслийг боловсруулахаар тусгасан бөгөөд үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулахаар олон улсын зөвлөх сонгон шалгаруулан хуулийн төсөл боловсруулах хүрээнд нэр бүхий 5 улсын эрх зүйн орчны судалгааг хийж, тайланг гаргасан. Мөн түүнчлэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төслийг дагаж гаргах дүрэм, журам, салбарын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд Ажлын албаны даргын 2021 оны №А/62 тушаалаар “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх баг”-тай гэрээ байгуулан 2022-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулсан.

Мөн бид үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх иргэн хуулийн этгээдийн борлуулалтын мэдээг ХУР системээс хүлээн авах орчныг бүрдүүлэхээр “Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн QR, И-баримтын мэдээ”-ний загварыг боловсруулж, тусгай зөвшөөрөлтэй 396 иргэн, хуулийн этгээдэд цахим төлбөрийн баримт үүсгэх QR кодыг олгоод байна. Ийнхүү дээрх салбарыг үр дүнтэй зохицуулж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлснээр хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, зохицуулалттай этгээдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үндэсний брэндийг олон улсын зах зээлд гаргах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах зэрэг давуу тал бий болгон салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж тооцож байна.

## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

### НОГООН САНХҮҮЖИЛТИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛҮҮД

2022 он гарсаар таны эргэн тойронд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, ногоон санхүүжилт зэрэг нэр томъёолол түгээмэл гарч байгаа байх. Манай улсын хувьд Үндэсний тодорхойлсон хувь нэмэрт тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэх, шар шороон шуурганаас эх орноо хамгаалах зорилгоор тэрбум тарих гээд нэлээдгүй санхүүжилт шаардсан ажлуудыг 2030 он хүртэл хийхээр төлөвлөөд байгаа билээ.

Санхүүгийн зах зээлээс ногоон, тогтвортой санхүүжилтээр дамжуулан хөрөнгө оруулалт татахад ямар төрлийн санхүүгийн хэрэгслүүд байдаг талаар сонирхол татсан тул судалж үзэхэд Ази–Номхон далайн орнууд гэж нэрлэгддэг ASEAN+3 орнууд уг чиглэлээр багагүй олон шинэ санхүүгийн бүтээгдэхүүнүүд гарган санхүүжилт татсан туршлагын талаар олж мэдсэнээ та бүхэнд хүргэхээр орууллаа.

#### Ногоон бондын төрлүүд:



Өрийн хэрэгслийн төрлүүд	Тодорхойлолт	Жишээ
Олон улсын ногоон бонд	Олон улсад гаргадаг бонд ба бонд гаргагч улс нь зэрэглэл тогтоодог. Зарим тохиолдолд хөндлөнгийн зэрэглэл тогтоодог байгууллагаар зэрэглэлийг үнэлүүлдэг.	Индонез улс 2018 онд сэргээгдэх эрчим хүч, ногоон барилга, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон аялал жуулчлал, байгалийн нөөцийн тогтвортой удирдлага зэрэг төслүүдийг санхүүжүүлэхээр 5 жилийн хугацаатай 1.25 тэрбум ам.долларын олон улсын ногоон бонд гаргасан.
Хариуцлагатай ногоон бонд	Төсөл нь нэрлэсэн хөрөнгө болон төсөлд хуваарилагддаг. Ногоон бонд нь үнэт цаас гаргагчийн орлогоор баталгааждаг.	2014 онд энэ төрлийн бондыг Хавай мужаас гаргаж байсан ба хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь ногоон дэд бүтцийн шимтгэлээр баталгаажсан. 2017 онд Бээжингийн усны компани 16 мужтай гэрээ байгуулж, 19 төрлийн усны төхөөрөмжийн шимтгэлд суурилсан үнэт цаасыг гаргасан.
Ногоон бүтэцлэгдсэн санхүүжилт	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас ба зээлийн эрсдэл нь хөрөнгийн эрсдэлээс хамаардаг.	Австралийн үндэсний банк нар, салхины төхөөрөмжийг дахин санхүүжүүлэхээр 2018 онд 200 сая австрали долларын ногоон бүтэцлэгдсэн санхүүжилтийг гаргасан.
Ногоон үнэт цаасжуулалт	Хөрөнгөөр баталгаажсан өрийн үнэт цаас бөгөөд зээлийн эрсдэл нь хөрөнгийн эрсдэлээс хамаардаг.	Австралийн Flexigroup нь нарны эрчим хүчний дэлгэцийг дахин санхүүжүүлэхээр 3 хөрөнгөөр баталгаажсан ногоон үнэт цаасыг гаргасан.
Ногоон хөрвөгч бонд	Үнэт цаас нь компанийн энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй.	Sumitomo forestry компани нь анхны ногоон хөрвөгч бондыг 2018 онд гаргасан.
Ногоон төслийн бонд	Зээлийн зэрэглэл нь төслийн үр өгөөж болон баталгаа гаргаж буй ногоон хөрөнгөөс хамаардаг.	2017 оны 8 дугаар сард Америкийн хөрөнгө оруулалтын корпорац 20 жилийн хугацаатай 135.8 сая долларын бондыг Уругвайд байрлах салхин фермийг санхүүжүүлэхээр татсан.
Байгаль орчны нөлөөллийн бонд	Төслийн эрсдэлийн нэг хэсэг нь үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч руу шилждэг. Хөрөнгө оруулагчид төлөх төлбөр нь гуравдагч талын үнэлгээ гарсны дараа төслийн хүлээгдэж буй үр дүн болон хүрсэн байдлаас хамаарч төлөгддөг.	2016 онд анх гарч байсан үнэт цаас.
Private placement		
Мезанин бонд	Хосолсон хөрөнгө оруулалтын хэлбэр ба хөгжлийн банкаас хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилготой гаргасан.	Хөрөнгө оруулалтын менежментийн компани болох AMP капитал нь Францын сэргээгдэх эрчим хүчний компанид 245 сая еврогийн мезанин санхүүжилтийг олгож байсан.

Өрийн хэрэгслийн хувьд хүснэгтэд харуулсан шиг олон төрлийн ногоон санхүүжилтийг гаргаж буй туршлага улс орнуудад байдаг бөгөөд төрийн дэмжлэг мөн чухал байдаг. Тухайлбал, ногоон бонд гаргагчдад төрөөс үзүүлж буй дэмжлэгийн хувьд Сингапур улсын Төв банк ногоон бондын гадаад зардлыг гаргах ногоон бондын тусламжийн хөтөлбөр хэрэгжүүлсэн. Малайз улс 2020 он хүртэл ногоон бонд гаргагчдад татварын хөнгөлөлт, хөрөнгө оруулагчдыг татвараас чөлөөлсөн.

Ногоон санхүүжилттэй холбоотой бусад төрлийн үнэт цаасны хэрэгслүүдийг дараагийн дугаараар та бүхэндээ үргэлжлүүлэн хүргэх болно.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ФИНТЕК ДЭХ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРСДЭЛ

Финтек дэлхийн хэмжээнд санхүүгийн салбарыг хөгжүүлэх гол хүчин зүйл гэдгээрээ хүлээн зөвшөөрөгдөж, илүү үр ашигтай, өрсөлдөх чадвартай санхүүгийн зах зээлийг бий болгохын зэрэгцээ санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байна. Иймээс бодлого боловсруулагчдын өмнө тулгамдаж буй чухал асуудал бол финтекийн ашиг тус, боломжийг ашиглахаас гадна түүний эрсдлийг удирдах явдал юм. Зарим хөгжиж буй орнуудад дижитал бичил зээл нь зээлийн хүртээмжийг сайжруулсан бол зарим орнуудад хариуцлагагүй зээлийн улмаас зээлээ төлж чадахгүй байгаа олон тооны зээлдэгчид бий болсон. Хөгжиж буй дийлэнх зах зээлд цахим мөнгө ихээхэн хэмжээгээр нэмэгдэж байгаа ч залилан мэхлэх, шударга бус байдлаас болж мөнгөө алдах зэрэг хэрэглэгчдийн хувьд янз бүрийн эрсдлийг дагуулж байна.




КОВИД-19 цар тахал нь хэрэглэгчдийн дижитал санхүүгийн үйлчилгээ болон финтек рүү шилжих шилжилтийг хурдасгаж, тэдний ач тусыг онцлон харуулахын зэрэгцээ эдийн засгийн хямралын үед хэрэглэгчдэд учрах эрсдэл хэрхэн нэмэгдэж байгааг мөн харуулж байна. Цар тахлын улмаас бага орлоготой хэрэглэгчдийн ихэнх нь өрөө төлөхөд бэрхшээл тулгарч байна. Мөн залилан мэхэлсэн апп-д суурилсан дижитал бичил зээл олгогчдын тоо мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.

Финтек бизнесийн загваруудын шинэлэг, тодорхой бус байдал, тэдгээр бизнесийн загваруудын хүрээнд финтекийн

байгууллагуудын үүрэг хариуцлага, хэрэглэгчдэд шинэ саналуудыг сайн мэдэхгүй, ойлгодоггүй зэрэг хүчин зүйлүүд нь финтекийн аж ахуйн нэгжүүд эсвэл гуравдагч этгээдийн залилан мэхлэх, зүй бус үйлдлийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд хүргэдэг. P2P зээл ба хөрөнгө оруулалтад суурилсан олон нийтийн санхүүжилт нь зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч болон зээлдэгчдэд эрсдэл учруулдаг. Тухайлбал хууран мэхлэх замаар зээл олгох, хөрөнгө оруулалтын боломж олгох, хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах, эсвэл шимтгэлийн орлого олохын тулд тооцоогүй зээл олгох, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх зэрэг нь эцэстээ хэрэглэгчдэд хохирол учруулдаг.

Финтекийн бизнесийн загваруудын тодорхой шинж чанарууд түүний хэрэглэгчид болон финтекийн байгууллагуудын хооронд ашиг сонирхлын зөрчилд хүргэдэг. Жишээлбэл, финтекийн байгууллагуудад шинэ бизнесээс бий болсон шимтгэлээс ихээхэн хамааралтай зээлийн загварууд нь P2P зээлийн платформ эсвэл дижитал бичил зээлийн үйлчилгээ үзүүлэгч гэх мэт хэрэглэгчдийнхээ ашиг сонирхолд үл нийцэх үйл ажиллагаа явуулах хөшүүрэг болж, чанараас илүүтэйгээр зээлийн тоонд анхаарахад хүргэдэг. Финтекийн байгууллагууд орлого, хэмжээгээ хурдан нэмэгдүүлэхийг оролдож байгаа зах зээлд ийм эрсдэл улам бүр нэмэгддэг.

Хэрэглэгчид уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүнд хандахаас илүү финтекийн бүтээгдэхүүн худалдан авахдаа кибер залилан мэхлэлтэд өртөх тохиолдлууд байна. Үйлчилгээ үзүүлэгчидтэй харилцах нь зөвхөн дижитал болон алсын зайн хэрэгслээр дамждаг. Платформ болон бусад технологийн доголдол нь хэрэглэгчдэд таагүй, муу үйлчилгээ үзүүлэхээс эхлээд мөнгөний алдагдал, өгөгдлийн бүрэн бүтэн байдал алдагдах зэрэг сөрөг нөлөөг үзүүлдэг. Мөн финтекийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлж байгаа нь хүртээмжийг нэмэгдүүлж байгаа боловч нөгөө талаар бүтээгдэхүүний тохиромжгүй байдал, хэрэглэгчийн туршлагаас шалтгаалан илүү их эрсдэл дагуулдаг.



## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ТОГТВОРТОЙ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ БҮРДҮҮЛЭХ, ТҮҮНИЙ ЦАР ХҮРЭЭГ ХУРДАСГАХАД ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

#### ХУРААНГУЙ

Байгаль орчны доройтол, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, нийгмийн тэгш бус байдал, эдийн засгийн боломжоос хүн бүр тэгш оролцоотойгоор хүртэх зэрэг бидний өмнө тулгамдаж буй асуудлуудыг дэлхий нийтээрээ шийдвэрлэхээр нэгдэж Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг дэвшүүлсэн. Энэхүү судалгааны ажилд хөрөнгийн зах зээлийн байгаль орчин, нийгэмд ээлтэй хөрөнгө оруулалтын экосистемийн зураглалыг гаргаж, оролцогч талуудын үүрэг, ногоон, нийгэмд ээлтэй бүтээгдэхүүнийг хөгжүүлэх хөшүүргийн хамт оруулсан.

Түүнчлэн тогтвортой хөрөнгийн зах зээлийг өргөжүүлэх, хялбарчлахад технологийн дэвшлийг хэрхэн нэвтрүүлэх талаар судалсан нь шинэлэг юм.

#### ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 2015 онд Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг баталж улс орнууд ядуурлыг тэглэх, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлыг нөхөн сэргээх, тэгш байдлыг хангах, энх тайвныг цогцлооход нэгдсэн. Түүнчлэн мөн онд 196 орон Францын Парис хотноо уулзаж дэлхийн дулаарлыг цельсийн 2 градусаас бага түвшинд тогтоох уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээрийг баталсан. Улс орон, эдийн засгийн салбар бүр тогтвортой хөгжлийн төлөө нэгдэн ажилласнаар 5 гаруй жил болсон байна. Санхүүгийн зах зээл нь уг хөгжилд тогтвортой, ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтаар хувь нэмэр оруулдаг.

Санхүүгийн зах зээл нь байгаль орчны хувьд тогтвортой эдийн засгийн тогтолцоонд шилжихэд урт хугацааны хөрөнгө оруулалтын хэрэгцээг хангах ногоон хөгжлийг дэмжих санхүүгийн бүтээгдэхүүнийг бий болгож, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагчдад боловсрол олгох, ил тод байдлаар

#### Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа [narantuya@frc.mn](mailto:narantuya@frc.mn)  
Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Батболд [batbold\\_b@frc.mn](mailto:batbold_b@frc.mn)

хангах, нүүрстөрөгч бага ялгаруулалтад хөрөнгө оруулалтыг урамшуулж эрсдэлийг хамгийн бага, өгөөжийг өндөр түвшинд барих үндэсний болон олон улсын бодлогод дэмжлэг үзүүлдэг. Хөрөнгийн биржүүд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийн ил тод байдлыг илүү хангаж өгдөг давуу талтай.

Хөрөнгийн биржийн тогтвортой хөгжилд оролцох хамгийн чухал хүчин зүйлс нь: а) уур амьсгалын өөрчлөлт нь санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулдаг, б) олон улсын зохицуулагчид уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ил тод байдлыг нэмэгдүүлэхэд анхаарах болсон, в) хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын багцаа диверсификаци хийхийн тулд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийг эрэлхийлэх болсон.

Олон улсын хэмжээнд хөрөнгийн биржүүдийг тогтвортой хөгжилд чиглүүлэхээр Тогтвортой хөгжлийг дэмжигч биржүүдийн санаачилга, Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо хөрөнгийн биржүүдийг гишүүнчлэлээр элсүүлж байна. Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо ногоон, нийгмийн, тогтвортой гэсэн 3 төрлийн бондын зарчмыг гаргаж, зохицуулагчид, хөрөнгийн биржүүд тогтвортой, ногоон бондын зохицуулалтыг боловсруулахад тус зарчмуудыг удирдлага болгодог. Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос 2014 онд анх ногоон, нийгмийн, тогтвортой байдлын бондын зарчмууд боловсруулж, 2018 онд дахин шинэчилж байжээ.

Нэгдсэн Үндэсний байгууллагаас хариуцлагатай хөрөнгө оруулалтыг бий болгох зорилгоор Тогтвортой хөрөнгийн зах зээлийн санаачилгыг байгуулсан. Тогтвортой хөрөнгийн зах зээлийн санаачилгад хөрөнгийн биржүүд болон санхүүгийн зохицуулагч нар нэгдэх ба Тогтвортой хөгжлийн хэд хэдэн зорилгыг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэн ажилладаг. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын 12.6 дахь зорилтын хүрээнд хөрөнгийн биржийн хувьд компаниудыг байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдлын

аргачлал, маягтыг гаргаж, хөрөнгө оруулагчдыг мэдээллийн ил тод байдлаар хангадаг. Тогтвортой хөрөнгийн зах зээлийн санаачилгад 107 бирж, 16 зохицуулагч нэгдсэнээс байгаль орчин, нийгэм, засаглалын тайлангийн загварыг нийт гишүүнчлэлтэй биржүүдийн 53 хувь буюу 57 нь уг тайлагналын стандартыг гарган хувьцаат компаниуд тайлагнах болсон.

ТХЗ-ын 13.3 дахь зорилтод хүрэхэд ногоон санхүүжилтийг бий болгох төлөвлөгөөг гаргасан ба 38 хөрөнгийн бирж буюу нийт гишүүнчлэлтэй биржүүдийн 35 хувь нь ногоон санхүүжилтийн орчныг бүрдүүлээд байна. Хөрөнгийн бирж нь үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч нарыг нэг цэгт уулзах үүргийг гүйцэтгэдгийн хувьд байгаль орчин, нийгэм, засаглалын мэдээллийг түгээх платформ, тогтвортой хөрөнгийн дэд бүтцийг бүрдүүлэгч, алтернатив санхүүжилт, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарыг санхүүжүүлэгчтэй нь холбогч гүүр нь юм.

**ТХЗ-ын 5.5 дахь зорилт буюу хүйсийн тэгш байдлыг хангахад 95 хөрөнгийн бирж буюу гишүүнчлэлтэй биржүүдийн 93 хувь нь нэгдсэн. Жил бүрийн Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр хүйсийн эрх тэгш байдлын ач холбогдлыг эргэн санах зорилгоор тус 95 бирж “Хонх цохих” арга хэмжээг зохион байгуулдаг байна.**

ТХЗ-ын 8.3 дахь зорилтод хүрэхэд нийгэмд ажил эрхлэлтийг бий болгодог жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн таатай орчныг бүрдүүлэх юм. Үүний тулд хөрөнгийн биржүүд санхүүжилтийн эрэлт талаас засаглалыг сайжруулах,

байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийн зохицуулагч нь тогтвортой хөрөнгийн зах зээлийг бүрдүүлэхэд шаардлагатай 5 зорилго бүхий төлөвлөгөөг боловсруулжээ.

Сүүлийн жилүүдэд биржүүд тогтвортой хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа явуулах хандлага нэмэгдсэн ба бирж тогтвортой байдлын тайлан гаргах, сургалт явуулах, байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур тогтоох, тайлагналын зөвлөмж болон индекс гаргах үйл ажиллагаануудыг хийж байна.


Тогтвортой санхүүжилт гэдэг нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн тэнцвэрийг хангахад байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагаанд санхүүжилт олгохыг хэлнэ. Үүний тулд санхүүжилт олгогч тал санхүүжүүлэгч хүсэгч талын байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлын үнэлгээг хийдэг.

### ТОГТВОРТОЙ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭКОСИСТЕМ

Хөрөнгийн бирж тогтвортой санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр үүсэх боломж нь зах зээлийн шинэ сегментийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчдын эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн нэмэгддэг. Ийнхүү шилжихэд зах зээлд оролцогчдод боловсрол олгох, стандарт боловсруулах, платформ бий болгох зэрэг цогц шаардлагыг хангах төлөвлөгөөг Тогтвортой хөрөнгийн биржийн санаачилгаас гаргасан.

Тогтвортой хөрөнгийн зах зээлийн экосистем нь дараах оролцогчид, бүтээгдэхүүнээс бүрдэнэ:

Зураг. Тогтвортой хөрөнгийн зах зээлд хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөө



Эх сурвалж: SSEInitiative

нийлүүлэлт талаас таатай орчныг бүрдүүлэхэд ажиллаж байна.

ТХЗ-ын 10.5 дахь зорилтод хүрэхэд Тогтвортой хөрөнгийн биржийн санаачилга нь 70 гаруй хөрөнгийн зах зээлийн оролцогчдоос бүрдсэн ажлын хэсэгтэй хамтран ажиллаж

1. Хөрөнгийн бирж
2. Зохицуулагч байгууллага
3. Ногоон бүтээгдэхүүн
4. ESG тайлагнал
5. Хариуцлагатай хөрөнгө оруулагч

### Үйл ажиллагааны төлөвлөгөө

Тогтвортой хөрөнгийн зах зээлийн экосистемийн оролцогчид болон тэдгээрийн холбоо хамаарлыг багтаасан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулснаар тогтвортой, ногоон хөрөнгийн зах зээлийг системтэйгээр бий болгох боломжтой.

Хөрөнгийн зах зээлийг тогтвортой тогтолцоо руу шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Тогтвортой хөгжлийг дэмжигч биржүүдийн санаачилгаас гаргаж, биржүүд хэрэгжүүлж байгаа ба Зурагт харуулав.

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь үндсэн 4 хэсгээс бүрдэх ба үүнд:

Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих

Санхүүгийн зах зээлийг ногоон болгох

Байгаль, орчны ил тод байдлыг нэмэгдүүлэх

Хамтын ажиллагааг өргөжүүлэх багтана.

### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА БЛОКЧЭЙН

Тогтвортой хөрөнгийн зах зээлийг бүрдүүлэхэд хөрөнгө оруулагчдын эрэлтийг хангах нийлүүлэлт хомс, ногоон бүтээгдэхүүний хөрвөх чадвар хангалтгүй, ногоон санхүүжилтийн талаарх ойлголт бага, биржүүдийн хязгаарлагдмал үйл ажиллагаа, зохицуулалтын нөлөө, тоон өгөгдлийн хангалтгүй байдал нь гол сорилт болж байна.

(Carman Nadia Ciocoiu) Өнгөрсөн 5–10 жилд ногоон эдийн засгийг мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилан хурдасгасан дэвшил хөгжиж буй орнуудад гарснаар гурван дамжлагаар нөлөө үзүүлсэн:

Мэдээлэл, харилцаа холбооны технологиор дамжин үйлдвэрлэл, түгээлт, үйл ажиллагааны явцад шууд нөлөө үзүүлэн сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж, токсик материалын хэрэглээ буурч, хог хаягдлыг дахин боловсруулах ажиллагаа сайжирсан.

Виртуал бүтээгдэхүүн, үйлчилгээний орлуулах боломжоор цахилгаан зарцуулалтыг бууруулсан ба дэлхий даяар нийтдээ 30 хувиар багасгах боломжтой.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар нь бусад салбартай хамтран ажилласнаар иргэн, хэрэглэгч, Засгийн газар, эдийн засаг, нийгмийн бүлгүүдийн зан төлөв, хандлага, үнэ цэнэ өөрчлөгдсөнөөр системийн хэмжээнд үр нөлөө үзүүлнэ.

Тогтвортой хөрөнгийн зах зээлийн орчинд үнэт цаас гаргагчдын хувьд тайлагнал, хариуцлага нэмэгдэх ба үүнийг технологийн шийдлээр хялбарчлах боломж бий. Учир нь байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийн мэдээлэл дутагдалтай байдгийн улмаас мэдээллийн тэгш бус байдал үүсэн, тухайн мэдээллийг олж авахад нэмэлт цаг, зардал гардаг.

Дижитал санхүүжилт буюу их өгөгдөл, хиймэл оюун ухаан,

Зураг. Блокчэйн технологийн ашиглалт, 2021



мобайл платформ, блокчэйн, юмсын интернэт холболт (IoT) нь дээрх асуудлуудыг шийдвэрлэж, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг дэмжинэ. Ингэснээрээ дижитал шилжилт нь хөрөнгө оруулагчдад байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөллийн талаарх мэдээллийг хүргэснээр зардал хэмнэж, эрсдэлийг илрүүлж, инновац, хүртээмжийг нэмэгдүүлэх юм.

**Тогтвортой хөгжлийн зорилтууд ба блокчэйн**

Блокчэйн технологи нь анх 2009 онд биткойны арилжааг бүртгэх бүртгэл хэлбэрээр бүтээгдсэн бол өнөөдрийн байдлаар мэдээллийг аюулгүй солилцох, хөрөнгийн бүртгэл, бичиг баримтын үнэн зөв байдлыг хянах зэрэг олон төрлөөр ашиглагдаж байна.

Блокчэйний ил тод, үр ашигтай, хурдан байдлыг санхүүгийн зах зээлээс гадна бүхий л салбарт ашиглаж болох ба Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд блокчэйн технологийг ашиглах кэйсүүд олон байна. Блокчэйн технологийг ашиглан:

**Төлбөр тооцоо хийх:** Зорилтот бүлэгт санхүүжилтийг хүргэж, төлбөр тооцооны найдвартай, ил тод, түргэн шуурхай байдлыг хангах

**Мэдээллийг хүргэх, баталгаажуулах, тархаан байршуулах:** Интернэтэд холбогддог тохиолдолд блокчэйн байршуулсан мэдээллийг хэн ч харах боломжтой ба тус мэдээллийн аюулгүй, найдвартай, түргэн шуурхай байдлаар хүргэх замаар Тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд байна /Хавсралт 1/.

**Тогтвортой хөрөнгийн зах зээлд блокчэйн технологийг ашиглах нь**

Блокчэйн технологийн Тогтвортой хөгжлийн зорилтуудад ашиглахаас гадна тогтвортой хөрөнгө оруулалтад ашиглах боломжтой

**Хувьцааны төвлөрсөн хадгаламж**


Хувьцаа, үнэт цаас нь ихэнх тохиолдолд хувьцаа эзэмшигч өөрт нь биш, тусгай төвлөрсөн хадгаламжийн төвд бүхлээрээ хадгалагдсан байдаг бөгөөд өмчлөлийн бүртгэл хөтлөх замаар хуваарилсан байдаг. Үнэт цаасны бүртгэлийн төвлөрлийг сааруулах, эрсдэлийг бууруулах зорилгоор энэ чиглэлд 2 аргаар блокчэйн технологийг нэвтрүүлэх боломжтой гэж үздэг:

**Үнэт цаасны бүртгэлийг нэг биш олон цэгт байршуулах:** Энэ ойлголт нь мэдээллийг тараан байршуулж, олон цэгт хадгалах гэсэн утгатай ба нэг сул тал нь мэдээллийг засварлахад төвөгтэй байх эрсдэлтэй.

**Бүртгэлийн мэдээллийг олон хэсэгт хувааж токенжуулснаар, токен эзэмшигчдийн мэдээлэл, токений хөдөлгөөнийг блокчэйн ашиглан бүртгэх:** Энэ нь криптовалюттай дөхөм ойлголт буюу компани блокчэйн ашиглан хувьцаагаа крипто токен хэлбэрээр гаргахтай холбоотой юм. Ингэснээр хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг дижитал хэлбэрээр хадгалан, хувьцааны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын үйл ажиллагаа илүүц болно.

АНУ-ын Делавер мужид хувьцаат компаниудыг блокчэйн ашиглан хувьцааг олон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн

*Зураг. Блокчэйн технологийн онцлог ба нөлөө*



боловч ойрын хугацаанд олон нийтэд хувьцаагаа шинээр санал болгож буй компаниуд л хэрэгжүүлэх боломжтой байна.

### Хувьцаа эзэмшигчдийн цахим санал өгөх платформ

Компанийн хувьцаа эзэмшигчдийн санал хураалт уламжлалт байдлаар явагдахад хэд хэдэн асуудал байдаг нь хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, шударга, найдвартай санал хураалт зэрэг байдаг ба эдгээрийг шийдэхэд блокчэйнийг ашиглах боломжтой. Блокчэйний тусламжтайгаар хувьцаа

эзэмшигчийн санал хураалт ил тод, үнэн зөв явагдах юм. Мөн санал тоолох үед гардаг алдаа зэргээс ч сэргийлэх боломжтой.

Энэ утгаараа блокчэйнийг тайлагналын үйл ажиллагаанд ашигласнаар ил тод, аюулгүй, үр ашигтай, баталгаатай мэдээлэл гаргаж, хөрөнгө оруулагчдын итгэлийн нэмэгдүүлэхээр ашиглаж байна.

## САНАЛ, ДҮГНЭЛТ

Дэлхийн олон улс орнууд, тэдгээрийн хөрөнгийн бирж нь тогтвортой хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хувьцаат компаниуд, хөрөнгө оруулагчдын тогтвортой, ногоон үйл ажиллагааг дэмжих чиглэлийг баримталж байна.

Тогтвортой хөрөнгийн зах зээлийн тогтолцоонд шилжихийн тулд хариуцлагатай хөрөнгө оруулагч, тогтвортой хөрөнгийн бирж, тайлагнал, ногоон бүтээгдэхүүн гээд цогц экосистемийг бүрдүүлэх шаардлагатай байдаг ба үүнийг дагаад биржүүд болон хувьцаат компаниуд сорилттой тулгарч байна. Тухайлбал компаниудын хувьд ногоон хөгжлийн зорилтод нийцсэн байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан гаргах, хөрөнгө оруулагчдад шаардлагатай мэдээллийг бэлтгэх нь цаг хугацаа болон зардлаар хязгаарлагдаж буй нь тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэхэд бэрхшээл авчирдаг. Харин үүнийг Сингапурын сиббертек бирж нь блокчэйнд суурилсан хөрөнгийн биржийг байгуулж, түүгээрээ тогтвортой санхүүжилтэд суурилсан токен арилжих, Люксембургийн хөрөнгийн бирж блокчэйнд суурилсан мэдээлэл хуримтлуулах технологийг нэвтрүүлснээрээ шийдвэрлэж байна.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл нь харьцангуй жижиг, хөгжих шатандаа явж байгаа тул бусад улс орнуудын туршлагад үндэслэн тогтвортой буюу ногоон зах зээлийг бий болгож, бүтээгдэхүүн үйлчилгээний төрлийг олшруулахад дэвшилтэт технологийг ашиглах боломжтой. Үүнд хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дижитал биржийн тогтолцоонд шилжүүлэх, мэдээлэл цуглуулах процессыг автоматжуулах, түүнчлэн тогтвортой хөрөнгийн зах зээлийн экосистемийг бүрдүүлэх цогц ажиллагаа шаардлагатай.

## ЭХ СУРВАЛЖ:

“HOW STOCK EXCHANGES CAN GROW GREEN FINANCE.” SSE, 2019,

<https://sseinitiative.org/wp-content/uploads/2019/12/SSE-Green-Finance-Guidance-.pdf>

“A Roadmap for Sustainable Capital Markets: How can the UN Sustainable Development Goals harness the global capital markets?”

Aviva, 2014,

<https://www.unepfi.org/psi/a-roadmap-for-sustainable-capital-markets-how-can-the-un-sustainable-development-goals-harness-the-global-capital-markets-an-aviva-white-paper/>

“Responsible investment and Blockchain”, PRI, 2018,

<https://www.unpri.org/download?ac=4522>

“How will ESG performance shape your future?”, Ernst & Young, 2020

[https://assets.ey.com/content/dam/ey-sites/ey-com/en\\_gl/topics/assurance/assurance-pdfs/ey-global-institutional-investor-survey-2020.pdf](https://assets.ey.com/content/dam/ey-sites/ey-com/en_gl/topics/assurance/assurance-pdfs/ey-global-institutional-investor-survey-2020.pdf)

“Blockchain-Based Solutions in Achieving SDGs after COVID-19”, Ahmet Faruk Aysan, 2021

<https://www.mdpi.com/2199-8531/7/2/151>



## БОНД ГЭЖ ЮУ ВЭ?

**Бонд гэдэг нь:** Тогтмол орлоготой, эрсдэл багатай үнэт цаас.

Компанийн бондод хөрөнгө оруулж байгаа нь **тухайн компанид мөнгө зээлж байна** гэсэн үг ба үүний хариуд **компани ашигтай ажилласан эсэхээс үл хамааран** хөрөнгө оруулагчид үндсэн мөнгө болон хүүг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлдөг.

## БОНДЫН ХУГАЦААНЫ АНГИЛАЛ



Богино хугацаатай  
/1–3 жил/



Дунд хугацаатай  
/3–5 жил/




Урт хугацаатай  
/5–аас дээш жил/

## БОНД БОЛОН ХУВЬЦААНЫ ЯЛГААТАЙ ТАЛ

### БОНД

1. Тодорхой хугацааны дараа **эргэн төлөгдөнө**
2. Зээлдүүлэгчийн хувьд **зээлийн хүүг авна**
3. Хөрвөх чадвар хувьцаанаас сул
4. Зээлийн хугацаанд хүчинтэй
5. Компани дампуурвал өөрийн зээлдүүлсэн хөрөнгийг хүүгийн хамт **хамгийн түрүүнд авна.**



1. **Эргэн төлөгдөх нөхцөлгүй**
2. Өмчлөгчийн хувьд өөрт ногдох **ногдол ашиг хүртэнэ**
3. Хөрвөх чадвар сайтай
4. Компани оршин тогтнох **бүхий л хугацаанд хүчинтэй**
5. Компани дампуурвал өөрт ногдох хөрөнгийг өр төлбөр, зээлийг **барагдуулж дууссаны дараа авдаг.**

### ХУВЬЦАА



Монгол Улсын хамгийн анхны  
**дигитал бонд** гарсан шүү.

Дигитал гэж онцолж байгаа нь бүх шат дамжлага аппликейшн дээр хийгдэнэ. Хамгийн анхны дигитал бонд 2021 оны 11 дүгээр сард гарсан.

Тийм үү? Бас **ногоон бонд** гаргах боломжтой болсон юм байна лээ.

Үнэт цаас гаргагч нь ногоон бонд зарахдаа борлуулалтын орлогыг байгаль орчинд ээлтэй төслүүдэд зориулах үүрэг хүлээдэг.



## НОГООН БОНДООР САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮД



Нөхөн сэргээгдэх эрчим хүч



Эрчим хүчний үр ашигтай зарцуулалт



Байгальд ээлтэй тээвэр



Дахин ашиглах хог хаягдлын менежмент

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЛҮҮД



# САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

## САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛД СУРАЛЦЬЯ (ХИЧЭЭЛ №4)



Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.ЭНХБААТАР

### Дискаунт фактор

Өмнөх хичээлд мөнгөний ирээдүйн үнэ цэнийг хорогдуулах (дискаунт) аргаар өнөөгийн үнэ цэнийг тооцоолсон. Мөнгөний ирээдүйн үнэ цэнийг энгийн

хүүтэй нөхцөлд тухайн мөнгөний хэмжээг  $(1 + i \times \frac{\text{өдөр}}{\text{жил}})$ , нийлмэл хүүтэй нөхцөлд  $(1 + i)^N$  хуваагчид хувааж тооцоолно. Эдгээр хуваагчийг англиар 'фактор' гэх бөгөөд 'нэг'-ийг эдгээр факторт хуваасан хэлбэрийг 'хорогдуулах хуваагч' буюу 'дискаунт фактор' (discount factor) гэнэ.

А тоог  $(1 + i)^N$  хуваах илэрхийлэл  $\frac{A}{(1+i)^N}$  байна, эндээс гарах дараах тэнцэл үнэн бөгөөд шараар тодруулсан хэсэг нь дискаунт фактор юм.

$$\frac{A}{(1+i)^N} = A \times \frac{1}{(1+i)^N}$$

Жишээ1:

7.8% хүүтэй 92 хоногийн дискаунт фактор хэд вэ? 92 хоногийн дараах 100 төгрөгийн одоогийн үнэ цэнэ хэд вэ? (энгийн хүү)

$$\text{Дискаунт фактор} = \frac{1}{1 + 0.078 \times \frac{92}{365}} = 0.9807$$

$$₮100 \times 0.9807 = ₮98.07$$

Жишээ2:

8.5% нийлмэл хүүтэй 3 жилийн дискаунт фактор хэд вэ? 3 жилийн дараах 100 төгрөгийн одоогийн үнэ цэнэ хэд вэ?

$$\text{Дискаунт фактор} = \frac{1}{(1+0.085)^3} = 0.7829$$

$$₮100 \times 0.7829 = ₮78.29$$

Энгийн хүүгийн нөхцөлд:

$$\text{Дискаунт фактор} = \frac{1}{1 + i \times \frac{\text{өдөр}}{\text{жил}}};$$

Нийлмэл хүүгийн нөхцөлд:

$$\text{Дискаунт фактор} = \left(\frac{1}{1+i}\right)^N;$$



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХЯНАЛТ

### 2022 ОНД АНХААРАХ ГОЛ ЧИГЛЭЛҮҮД

ТУЗ-ийг анхаарал хандуулах шаардлагатай асуудлын талаар цаг тухайд нь бүрэн мэдээллээр хангаж, хэлэлцэх асуудлын тэргүүлэх чиглэл, холбогдох бүтэц, үйл явц, хяналтыг тогтмол үнэлэх нь ТУЗ-ийн гишүүдийн хяналтын чиг үүргээ хангалттай сайн биелүүлэхэд нь тусалдаг.

ТУЗ-ийн үндсэн үүрэг нь гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлд хяналт тавихаас гадна компанийн засаглалын асуудал, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал, залгамж халааны бодлого, хөндлөнгийн аудиторын хяналт, их хэмжээний хэлцлийн асуудал, ногдол ашгийн хэмжээ, дүрэм журмын өөрчлөлт зэрэг асуудлууд багтдаг.

ТУЗ-ийн хяналтын чиг үүрэгт стратегийн санаачилга, санхүүгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн үйл явцын найдвартай байдал, эрсдэлийн удирдлага, комплайнс зэрэг орно.

ТУЗ нь эрсдэл болон комплайнсын хяналтыг байнга хэрэгжүүлж чухал эрсдэлд маш хянамгай хандах ёстой. Өөрөөр хэлбэл компанийн стратеги, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, эрсдэлийн удирдлага, комплайнсын тогтолцооны хэрэгжилтийг хянана. Эрсдэл болон комплайнстай холбоотой асуудлууд гарах үед хариу арга хэмжээ авахад бэлэн буюу эрсдэл болон комплайнсын хяналтын бүтэцтэй байх ёстой.

Дийлэнх хувьцаат компаниудад аудитын хороо нь компанийн эрсдэлийн хяналтыг хариуцдаг бөгөөд аудитын хорооны гишүүд нь санхүүгийн мэдлэг туршлага бүхий хүмүүсээс бүрддэг ч, санхүүгийн бус эрсдэлтэй холбоотой асуудалд туршлагагүй байдаг. Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудалд төвлөрдөг хороодтой харьцуулахад эрсдэлийн эсвэл комплайнсын бие даасан хороо харьцангуй ховор байдаг. Корпорацийн Захирлуудын Үндэсний Холбооны (NACD) 2020 онд Russell 3000 компанид хийсэн судалгаанаас харахад ТУЗ-ийн ойролцоогоор 9% нь эрсдэлийн хороотой, 4% нь комплайнсын хороотой, 4% нь байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын хороотой байсан.

ТУЗ нь эрсдэл болон комплайнсын хяналтын хувьд зохих бүтэцтэй эсэхээ үнэлж, тухайн хороод нь ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь хүргэх зэрэг мэдээлэл, хяналтын тогтолцоонд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай.

Энэхүү нийтлэл нь ТУЗ-ийн гишүүдийн хяналт тавих чиг үүргийг нэгтгэн дүгнэж, 2022 онд ТУЗ-д ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудыг онцолсон. Үүнд:

- Стратеги ба эрсдэл
- Байгууллагын зорилго, байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) асуудлууд
- Хүний нөөц, ажиллах хүчний асуудал
- Хувьцаа эзэмшигчдийн оролцоо, идэвх
- Хямралын үеийн удирдлага
- ТУЗ гүйцэтгэх удирдлагын хоорондын харилцаа болон ТУЗ-ийн соёл

#### Стратеги ба эрсдэл

ТУЗ нь компанийн стратегийг хэлэлцэх, гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийн чанарыг үнэлэх болон бизнесийн тасралтгүй байдал, боломж, эрсдэл зэрэгт ихэнх цагаа зориулахын зэрэгцээ удирдлагаар хангаж, хяналт тавих чиг үүрэгтэй. Компанийн стратеги, компанийн гүйцэтгэлийн хөдөлгөгч хүчин зүйлүүд, бизнес болон улс төрийн орчинтой холбоотой эрсдэлийг удирдахад нь гүйцэтгэх удирдлагад туслах, компанийн эрсдэлийг тодорхойлох, удирдах үйл ажиллагаанд зохих нөөцийг зориулахад гол үүрэг гүйцэтгэдэг.

Стратегийн асуудлууд нь компанийн зорилго болон ESG-тэй холбоотой асуудлуудтай улам холбогдож байна. Жишээлбэл, хөрөнгө оруулагчид болон зохицуулагчид уур амьсгалын

өөрчлөлтөд ихээхэн анхаарал хандуулж байгааг харгалзан 2050 он гэхэд (боломжтой бол түүнээс өмнө) компаниуд нүүрстөрөгчийг тэглэх тухай амлалт өгч байна. Олон компаниудын хувьд энэ нь үйл ажиллагааны том өөрчлөлтийг бий болгоно. ТУЗ-үүд гүйцэтгэх удирдлагын хамт стратегийн сонголт, хувилбаруудыг, тэр дундаа бизнесийн өөр чиглэлд хөрөнгө оруулалт хийх боломжийн талаар авч үзэх ёстой.

### ТУЗ нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын цагийн ихэнх хугацааг стратегийн асуудал, тодорхой стратегийн төлөвлөгөө, компанийн урт хугацааны чиглэлд хандуулах;

Өнөөгийн нөхцөлд ямар боломжууд гарч ирэх, компанийн зорилго болон ESG-ийн асуудал нь компанийн стратегитай хэрхэн холбогдож байгаа, мөн оролцогч талуудын ашиг сонирхол, ESG, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлтөд анхаарал хандуулснаар ямар боломж, эрсдэлүүд гарч ирж байгааг гүйцэтгэх удирдлагатай хамтран тодорхойлох;

Гүйцэтгэх удирдлагын эрсдэлийг тодорхойлох, хянах, удирдах үйл явц болон стратегийн шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг удирдах;

Стратегийг хэрэгжүүлж, холбогдох эрсдэлийг удирдаж буй удирдлагын гүйцэтгэлд хяналт тавих;

Комплайнс, аюулгүй байдал болон бусад эрсдэлүүд нь зорилгын хувьд хэр чухал байж болох талаар мэдээлэлд үндэслэн бизнесийн дүгнэлтэд хүрэх;

ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурлаар эрсдэл ба комплайнсын журмын талаар тогтмол ярилцаж, эрсдэлийн удирдлага болон зорилтын чухал эрсдэлүүдийг жил бүр дор хаяж нэг удаа хянан хэлэлцэх;

ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурлаар онцгой нөхцөл байдалтай холбоотой эрсдэл ба комплайнсын асуудлуудын талаар тусгасан байх;

Үнэнч шударга, мэргэжлийн түвшний компанийн соёлыг бий болгох, компанийн зорилгод нийцсэн комплайнс, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, хадгалах талаар гүйцэтгэх удирдлагад хариуцлага хүлээлгэж ажиллах.


*Үргэлжлэл бий...*

*Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance*



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ОХУ–ын Төв банкны зүгээс бодлогын хүүг нэмэгдүүлэх шийдвэр гаргав.



Нөхцөл байдлаас шалтгаалж АНУ, ЕХ болон дэлхийн бусад улс орнууд ОХУ–ын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээ авч эхэлсэн нь рублийн ам.доллартой тэнцэх ханш 30 хувиар суларч, түүхэн доод түвшинд хүрэхэд нөлөөлсөн. Үүнтэй холбоотойгоор, ОХУ–ын Төв банк 02 дугаар сарын 28–ны өдрөөс эхлэн бодлогын хүүгээ 9.5 хувь байсныг 10.5 хувиар нэмэгдүүлж, 20.0 хувьд хүргэх шийдвэр гаргасан байна. Төв банкны зүгээс, цаашид гадаад, дотоод нөхцөл байдлаас үүсэх эрсдэл болон тэдгээрт санхүүгийн зах зээлийн үзүүлэх хариу үйлдлийг үнэлсний үндсэн дээр бодлогын хүүгийн талаар дахин шийдвэр гаргана гэж мэдэгдсэн.

### Австрали болон Украин Улсын худалдаа, нийлүүлэлт тасалдаж байна.

Омикроны дэгдэлтийг дөнгөж давж гарсан Австрали Улсын бизнесүүдийн үйл ажиллагаа тасалдах, ашигт ажиллагаанд томоохон цохилт өгч болзошгүй байна. Австрали нь дунджаар 40 сая гаруй австрали доллар (29 сая доллар)–ын үнэ бүхий бараа бүтээгдэхүүнийг Украинаас импортлодог бол 110 сая орчим австрали доллар орчим үнэлгээ бүхий бараа бүтээгдэхүүнийг экспортолдог байна. Дайны нөлөөллөөс хамаарч Австрали Улсын бизнес тасалдаж, даатгалын компаниудад сөргөөр нөлөөлж байна.

### Даатгалын компаниудын нөхцөл байдал хурцдаж байна.

AM Best агентлагийн мэдээлснээр, хөрөнгийн зах зээлийн уналт болон кибер халдлагын улмаас улс орнуудын даатгалын салбарт үзүүлэх нөлөөллийг их байна гэж таамаглаж байгаа бөгөөд тус агентлагийн санхүүгийн шинжээч "Цаашид хориг

арга хэмжээ авах нь ОХУ–ын эрсдэлийг дааж буй олон улсын даатгагчид болон давхар даатгагчдын хариуцах чадварт сөргөөр нөлөөлөх, олон улсын түншүүдтэй харилцах харилцаа муудах, мөн нөхөн төлбөрийг төлж чадахгүй байх эрсдэл бий болно" гэж дүгнэсэн. Эрчим хүч, дэд бүтцийн томоохон эрсдэлүүдийг даатгасан Лондонгийн зах зээлийн даатгагчид болон давхар даатгагчдын төлөх нөхөн төлбөрийн дүн огцом өсөх хандлагатай байна.

### Шинэ Зеланд, Их Британи чөлөөт худалдааны гэрээ байгууллаа.



Шинэ Зеланд болон Их Британийн эрх баригчид хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээрт гарын үсэг үзэглэлээ. Энэхүү гэрээг байгуулснаар Шинэ Зеландын бизнес эрхлэгчид Их Британийн зах зээлд урьд өмнө байгаагүйгээр чөлөөтэй нэвтрэх боломж бий болж байгаа бөгөөд гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш бараг бүх худалдаа нь татвараас чөлөөлөгдөж байгаа. Ингэснээр Шинэ Зеланд Улсын ДНБ–ийг нэмэгдүүлэх, жижиг дунд бизнесийг дэмжих, ажлын байрыг хадгалахад эергээр нөлөөлж байна.

2022 оны эцсээр Шинэ Зеландын эдийн засагт хамгийн багадаа 37 сая шинэ зеланд доллар (24.8 сая ам.доллар) төвлөрүүлж, Их Британи руу хийх нийт экспортын хэмжээг 50 хувиар нэмэгдүүлнэ гэж таамаглаж байна.

### АНУ–д шатахууны үнэ огцом нэмэгджээ.

Орос–Украины дайны улмаас АНУ–ын шатахууны үнэ огцом нэмэгдсэн ба өнгөрсөн сартай харьцуулахад 1 галлон буюу 4.54 литрийн бензин нь 9.3 хувиар өсөж 3.65 ам.долларт хүрсэн байна.

03 дугаар сарын 02-ны өдөр “WTI” маркийн нефтийн фьючерс хэлцлийн үнэ 8.2 хувиар өсөж, торх нь 111.89 ам.доллар болж, долоон жилийн өмнөх дээд үзүүлэлтэд ойртоод байна. Нефтийн үнэ баррель тутамдаа 120 ам.долларт хүрвэл дэлхийн эдийн засагт мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлнэ гэж шинжээчид таамагласан.

### Туркт инфляцын түвшин 54.4 хувьд хүрчээ.

Туркийн мөнгөн тэмдэгт болох лирийн ханш суларч, эрчим хүч болон хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом өссөн зэрэг шалтгааны улмаас 02 дугаар сард тус улсын инфляцын түвшин 54.4 хувьд хүрч, сүүлийн хорин жилийн дээд хэмжээндээ хүрчээ.

“Bloomberg” агентлагийн судалгаанд оролцсон 22 шинжээч Туркийн инфляцын түвшнийг дараа сард 52.5 хувьтай байна гэж таамаглаж байжээ.

### БНХАУ–д биткойны арилжаа огцом буурчээ.

БНХАУ–д явагдаж буй биткойны арилжааны хэмжээ дэлхий дээрх нийт гүйлгээний 90 гаруй хувийг эзэлдэг байсан бол одоо 10 хувь болж огцом буурсан хэмээн тус улсын банкнаас мэдээлжээ. Энэхүү бууралтын шалтгаан нь сүүлийн 10–н жилд БНХАУ криптовалютын худалдаа, олборлолтын эсрэг тэмцлээ эрчимжүүлсэнтэй холбоотой юм. БНХАУ 2013 онд биткойны арилжааг, 2017 онд криптовалютын биржүүдийн үйл ажиллагааг хориглох шийдвэр гаргаж байсан.

Криптовалютын арилжаа болон бусад хууль бус аргаар мөнгө татсан хэрэгт холбогдсон этгээдийг 10 жил хүртэлх хорих ялаар шийтгэнэ хэмээн 02 дугаар сард мэдэгдсэн.

### БНХАУ 2022 онд ДНБ–ээ 5.5 хувиар өсгөх зорилт дэвшүүлээ.



Бээжин хотноо болсон 13 дахь удаагийн Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын (БХАТИХ) 5 дугаар чуулганы нээлтийн хурлын үеэр Төрийн зөвлөлийн

Ерөнхий сайд Ли Көчян засгийн газрын ажлын тайланг танилцуулахдаа энэ тухай мэдэгдсэн байна.

Хот газарт 11 сая гаруй ажлын байр шинээр бий болгох, хотын ажилгүйдлийн түвшнийг 5.5 хувиас хэтрүүлэхгүй байх,

инфляцын гол хэмжүүр болох хэрэглээний үнийн индексийн өсөлтийг 3 орчим хувьд барих, үр тарианы гарцыг 650 сая тонноос багагүй байлгах зэрэг зорилтыг 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаагаа дурдсан. Түүнчлэн Хятад улс байгаль орчныг хамгаалж, гол бохирдуулагч бодисуудын ялгаралтыг бууруулахын тулд цаашид улам илүү ач холбогдол өгч ажиллахаа мэдэгдсэн байна.

БНХАУ–ын ДНБ 2021 онд 114.37 их наяд юаньд хүрч, 8.1 хувиар өссөн бөгөөд 6 хувиас багагүй хувиар өсгөнө гэсэн зорилтоо биелүүлж чадсан билээ.

### Еврогийн бүсийн инфляц 2022 онд 5.0 хувиас давах төлөвтэй байна.

Европын Төв банк Украинд болж буй дайн, эрчим хүчний эх үүсвэрүүдийн үнэ хурдацтай өсөж байгаатай холбогдуулан еврогийн бүсийн инфляцын талаарх таамаглалаа эрс өсгөөд байна. “Орос, Украины дайн болон үүнээс үүдэлтэй эрчим хүч, түүхий эдийн үнийн өсөлт болон олон улсын худалдааны саатал нь эдийн засгийн идэвхжил, инфляцад мэдэгдэхүйц нөлөөлж байгаа бөгөөд цаашдын сөрөг нөлөөлөл ямар түвшинд байхаас нөхцөл байдлаас хамаарна” гэж Европын Төв банкны дарга Кристин Лагард мэдэгдсэн.

Европын Төв банк нь 2021 оны 12 дугаар сард 2022 онд еврогийн бүсийн инфляцыг **3.2 хувьтай** байна гэж таамаглаж бол 2022 оны 03 дугаар сард **5.1 хувьтай** байна гэж таамаглаж байгаагаа мэдээлсэн.

### АНУ нь ОХУ–ын газрын тос, байгалийн хийн импортод хориг тавьжээ.

АНУ–ын Ерөнхийлөгч Жо Байден Украины эргэн тойронд үүссэн нөхцөл байдлын талаар үг хэлэхдээ “ОХУ–ын газрын тос, байгалийн хийн бүх импортод хориг тавьж байна” гэж мэдэгдсэн. “Ийм хориг арга хэмжээ нь АНУ–д шатахууны үнийг цаашид нэмэгдүүлэхэд хүргэнэ. Гэсэн хэдий ч үнийн өсөлтийг барихын тулд чадах бүхнээ хийнэ” гэдгээ мэдэгдсэн байна.


03 дугаар сарын 9–ний байдлаар АНУ–д шатахууны үнэ нэг галлон нь 4.17 ам.доллар давж, түүхэн дээд хэмжээнд хүрсэн байна. Америкийн эрчим хүчний компаниудад үнийг хөөрөгдөхгүй байхыг уриалж, нөхцөл байдлыг хэрэглэгчдийг хохироож өөрсдийн ашиг сонирхолд ашиглахгүй байхыг тус улсын Ерөнхийлөгч уриалсан.

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр

S&P 500 /^GSPC/


**4,277.88** +22.90 (+0.51%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/

**27,224.11** -155.23 (-0.55%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


**7,483.35** +15.97 (+0.21%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

**14,169.30** -22.50 (-0.16%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

